“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2026 оны 01 сарын 20 өдөр Улаанбаатар хот

№ 02/2026

Цаг агаарын нөхцөл байдал эрс хүйтэрч байгаатай холбогдуулан болзошгүй аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж

1. Цаг-уурын ил харааны станц, сансрын антен, глиссадын радио дохиологчийн антен зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байгууламж, тоног төхөөрөмжийн цасыг цэвэрлэх, мөстөлтөөс хамгаалах бодисыг технологийн дагуу хэрэглэж бэлэн байдлыг хангаж ажиллах.
2. Агаарын шугам, кабель шугам, тоног төхөөрөмжийн үзлэгийг хийх. Холболт, тусгаарлагч газардуулгын бүрэн бүтэн байдлыг шалгах. Конденсаци, мөстөлт, хяруу үүсэж богино холболт, газардлага гарахаас сэргийлэх,
3. Үндсэн болон нөөц дизель генератор, цахилгаан тэжээлийг сэлгэн залгах төхөөрөмж, холимог тэжээлийн систем, тасралтгүй тэжээлийн систем (UPS)-ийн тоног төхөөрөмжүүдийн үзлэг, шалгалтыг тогтмол гүйцэтгэх.
4. Нислэгийн үед нөөц дизель генераторыг зэрэгцээ ажиллагаанд байлгах ба өдөр бүр өглөө, оройд 10 минутаас доошгүй хугацаанд ажиллуулж шалгах. Дизель генераторын түлшний (өвлийн) нөөцийг хангалттай хэмжээнд байлгаж, хөдөлгүүрийн тос, хөргөлтийн шингэний түвшин, аккумуляторын цэнэгийг сайтар шалгаж байх.
5. Алслагдсан байгууламжийн ээлж солих болон албан томилолтоор ажиллах инженер, техникийн ажилтныг цаг агаарын хүнд нөхцөл болон хүчтэй салхи, шуурга, цасан болон үзэгдэх орчин хязгаарлагдсан үед аль болох замд гаргахгүй байх.
6. Тоног төхөөрөмжийн өрөөний халаалтын төхөөрөмж болон халаалтын зуух, радиатор, үлээх төхөөрөмж, дулаан дамжуулах хоолой, термостат зэрэг гол бүрэлдэхүүн хэсгүүдийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж, доголдол илэрвэл шуурхай мэдээлэн засварлах арга хэмжээг авах.
7. Алслагдсан байгууламжийн ээлж солих, албан томилолтоор ажиллах ажилтнууд замд гарахдаа өвлийн хөдөлмөр хамгааллын иж бүрэн хувцас болон хувийн бэлтгэлийг сайтар ханган, холбогдох нэгжтэйгээ тогтмол холбоо барьж, мэдээллийг өгч ажиллах.
8. Цаг агаарын тухай сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол авч, холбогдох мэдээллийг цаг алдалгүй дамжуулж, үйлдвэрлэлийн бэлэн байдлыг дээшлүүлэн бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллах
9. Үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагаатай холбоотой эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд АБЧУГ-т (88974030) мэдээлэх.

Утас: 976-88974030
Цахим шуудан: sqmd@ncac.mn